

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/14/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,
Тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан
Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 261663 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Ариунжаргал
Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn
Аудитор: Г.Өсөхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn
Аудитор: Д.Номингуа
Утас: 261740 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал	10
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө	14
3.4.2 Авлага.....	15
3.4.3 Бараа материал	16
3.4.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	17
3.4.5 Өр төлбөр	17
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт	19
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	20
3.5.3 Нэмэлт төсөв.....	22
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	22
3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт.....	22
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл.....	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	24
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	24
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:.....	24
4.4.3 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	27
4.4 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	28
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	29
5.1 Эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд:	29
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч:	29
5.3 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагад илэрсэн алдаа, зөрчил.....	31
5.3.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төв сан:.....	31
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	33

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БЗД	Баянзүрх дүүрэг
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
САГ	Санхүүгийн аудитын газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УТ	Улсын төсөв
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МТТ	Мэдээллийн технологийн төв
НД	Налайх дүүрэг
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
ХЧА	Хөдөлмөрийн чадвар алдалт
ЧД	Чингэлтэй дүүрэг



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Т.АУБАКИР
ТАНАА

2026.04.27 № 1149
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 169,121.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Чингис Хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн өмнөх оны үлдэгдэл 93,399.2 сая төгрөгөөс тайлант онд 12.4 хувь буюу 11,553.9 сая төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 81,845.3 сая төгрөгийн авлага бүрэн барагдаагүй эрсдэлтэй;
- Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас авах өмнөх оны үлдэгдэл 65,701.6 сая төгрөгийн авлагаас 12.4 хувь буюу 8,130.7 сая төгрөгийг барагдуулж, 57,570.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Олон жилийн насжилттай өмнөх оны үлдэгдэл 6,444.8 сая төгрөгийн авлагаас 9.8 сая төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 6,434.9 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулаагүй;

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дугаар зүйлийн 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 29 дүгээр зүйлийн 29.4, 37 дугаар зүйлийн 37.13.5, 37.14.4, 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6.0 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөг, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон байна. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж, тэтгэврийн нэмэгдэлд 300,100.0 сая төгрөгийг зарцуулж, дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөг болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700,000.0 сая төгрөгөөр тогтоожээ. Уг тогтоолын дагуу ХААН банканд 289,700.0 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд 176,200.0 сая төгрөг, Голомт банканд 158,400.0 сая төгрөг, Төрийн банканд 75,700.0 сая төгрөгийг 1 жилийн хугацаатай 15.0 хувийн хүүтэй тус тус байршуулж, тайлант онд 70,191.8 сая төгрөгийн хүүгийн өгөөж хүртэн нийгмийн даатгалын сангийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Бүгд Найрамдах Солонгос Улсад Монгол Улсын 2,224 иргэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 1,145.2 сая төгрөг, сайн дурын даатгалын шимтгэл 1,834.7 сая төгрөг, нийт 2,980.0 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 48.0 хувиар биелүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,170,997,547.4	3,151,468,044.7
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,430,750,807.3	2,255,832,553.8
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	726,713,755.3	868,268,949.0
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	13,532,984.8	27,366,541.9
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		300,000,000.0	300,000,000.0
6	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	300,000,000.0	300,000,000.0
7	Үнэт цаас		300,000,000.0	300,000,000.0
8	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		2,470,997,547.4	3,451,468,044.7
9	НИЙТ ӨР ТӨЛБӨР		89,138,145.2	146,297,958.5
10	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	89,138,145.2	146,297,958.5
11	Өглөг	17а, 17б	37,431,648.5	76,636,416.6
12	Урьдчилж орсон орлого	18а, 18б	51,706,496.8	69,661,541.9
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,381,859,402.1	3,305,170,086.2
14	Засгийн газрын хувь оролцоо		2,381,859,402.1	3,305,170,086.2
15	Хуримтлагдсан үр дүн		2,381,859,402.1	3,305,170,086.2
16	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		2,470,997,547.4	3,451,468,044.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		5,670,831,220.1	6,816,697,713.2
2	ТАТВАРЫН ОРЛОГО		4,440,903,987.7	5,233,092,185.2
3	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		4,440,903,987.7	5,233,092,185.2
4	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	38,732,883.5	1,583,605,528.0
5	Нийтлэг татварын бус орлого		38,732,883.5	131,417,309.4
6	Тусламжийн орлого		-	1,452,188,218.7
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,191,194,348.9	-
8	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	5,128,513,099.3	5,891,397,456.7
9	УРСГАЛ ЗАРДАЛ		5,128,513,099.3	5,891,397,456.7
10	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,002,941.8	999,437.6
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		789,660.7	922,621.4
12	Бараа үйлчилгээний бусад зардал		213,281.1	76,816.2
13	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,127,510,157.5	5,890,398,019.1
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		542,318,120.8	925,300,256.5
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		2,399.5	21,066.3
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		35,944,451.6	23,177.5
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		506,376,068.7	925,298,145.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,934,402,338.4	-	1,934,402,338.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(58,919,005.0)	-	(58,919,005.0)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,875,483,333.4	-	1,875,483,333.4
Тайлант үеийн үр дүн	506,376,068.7	-	506,376,068.7
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,381,859,402.1	-	2,381,859,402.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,987,461.2)	-	(1,987,461.2)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,379,871,940.9	-	2,379,871,940.9
Тайлант үеийн үр дүн	925,298,145.2	-	925,298,145.2
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,305,170,086.2	-	3,305,170,086.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,408,343,632.5	7,662,621,901.6
2	ТАТВАРЫН ОРЛОГО	5,193,657,922.5	5,103,701,242.0
3	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	5,193,657,922.5	5,103,701,242.0
4	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,711,742.2	2,558,920,659.5
5	Нийтлэг татварын бус орлого	39,711,742.2	1,106,420,776.0
6	Тусламжийн орлого	-	1,452,499,883.5
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,174,973,967.8	-
8	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,225,949,212.5	6,837,538,043.8
9	УРСГАЛ ЗАРДАЛ	6,225,949,212.5	6,837,538,043.8
11	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,047,595.7	12,728,850.2
12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	797,341.9	922,568.9
13	Бараа үйлчилгээний бусад зардал	6,250,253.7	11,806,281.3
14	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,218,901,616.9	6,824,809,193.6
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	182,394,420.0	825,083,857.8
16	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(2,111.3)
17	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	182,394,420.0	825,081,746.5
18	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,248,356,387.3	1,430,750,807.3
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,430,750,807.3	2,255,832,553.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,908,073,940,200.00	6,684,435,119,310.01	223,638,820,889.99	96.8
11	Татварын орлого	5,455,574,056,700.00	5,231,935,235,810.01	223,638,820,889.99	95.9
112	Нийгмийн даатгалын орлого	5,455,574,056,700.00	5,231,935,235,810.01	223,638,820,889.99	95.9
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	4,606,115,273,200.00	4,240,059,216,177.06	366,056,057,022.94	92.1
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	414,546,554,900.00	479,391,950,987.56	(64,845,396,087.56)	115.6
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	272,251,661,300.00	353,190,834,797.10	(80,939,173,497.10)	129.7
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	162,660,567,300.00	159,293,233,848.29	3,367,333,451.71	97.9
12	Татварын бус орлого	1,452,499,883,500.00	1,452,499,883,500.00	-	100.0
122	Тусламжийн орлого	1,452,499,883,500.00	1,452,499,883,500.00	-	100.0
122001	Хандив тусламж /дотоод/	1,452,499,883,500.00	1,452,499,883,500.00	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,802,223,694,500.00	5,846,916,869,264.94	(44,693,174,764.94)	100.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,869,455,865,400.00	5,848,516,867,764.94	20,938,997,635.06	99.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,387,147,400.00	922,568,862.11	464,578,537.89	66.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,387,147,400.00	922,568,862.11	464,578,537.89	66.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	747,524,200.00	611,024,714.68	136,499,485.32	81.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	639,623,200.00	311,544,147.43	328,079,052.57	48.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,868,068,718,000.00	5,847,594,298,902.83	20,474,419,097.17	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,868,068,718,000.00	5,847,594,298,902.83	20,474,419,097.17	99.7
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,868,068,718,000.00	5,847,594,298,902.83	20,474,419,097.17	99.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(67,232,170,900.00)	(1,599,998,500.00)	(65,632,172,400.00)	2.4
230001	Эргэж төлөгдөх зээл	(67,232,170,900.00)	(1,599,998,500.00)	(65,632,172,400.00)	2.4
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,105,850,245,700.00	837,518,250,045.07	268,331,995,654.93	75.7
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,105,850,245,700.00)	(837,518,250,045.07)	(268,331,995,654.93)	75.7
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,105,850,245,700.00)	(837,518,250,045.07)	(268,331,995,654.93)	75.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,430,750,807,259.34	(1,430,750,807,259.34)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,268,269,057,304.41	(2,268,269,057,304.41)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь эрхэм зорилгоо “Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд оролцогч талуудын тэгш оролцоотойгоор нийгмийн даатгалын эрх зүйн орчин, тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хүн амын насжилт, хөдөлмөр эрхлэлтийн хэв шинж, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тооны байдал зэрэг нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлтэй уялдуулан тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилж, олон давхаргат тогтолцоог бий болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, иргэдийнхээ нийгмийн баталгааг хангана.” гэж тодорхойлжээ.

Эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал:

- Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор НДЕГ болон Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 4 жилийн хугацаатай байгуулсан;
- Капитал банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банкнаас шилжүүлэн авсан хөрөнгүүдийг худалдан борлуулах зорилгоор НДЕГ-ын цахим хуудас, фэйсбүүк хаяг, Монголын мэдээ сонин, хамтран ажиллаж буй хөрөнгө зуучлалын байгууллагуудаар дамжуулан олон нийтэд түгээн ажилласан;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 75 дугаар захирамжаар төлбөрийн чадваргүйн улмаас санхүүгийн эрсдэлд орсон, татан буугдсан банканд байршиж байсан тусгай зориулалтын сан, төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг буцаан төвлөрүүлж, төрийг хохиролгүй болгох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Уг захирамжийн хүрээнд олон жилийн насжилттай төлөгдөх найдваргүй болсон иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой шүүхийн шийдвэр гарсан 780.6 сая төгрөг болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар татан буугдсан банкнуудтай холбоотой 5,458.9 сая төгрөг, нийт 6,239.5 сая төгрөгийн найдваргүй авлагыг хаах талаар газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр 01/2987 дугаар албан бичгээр холбогдох баримтын хамтаар Ажлын хэсгийн даргад хүргүүлсэн;
- Нийгмийн даатгалын төв сангийн өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд БЗД, СБД, ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд “Өндөргэгээн” ХХК, “Их тэргүүн” ХХК, “Монтех” ХХК-удыг эрэн сурвалжлуулахаар нэхэмжлэлийг гаргасан;
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-нд нийт 62 арга, хэмжээ зохион байгуулахаар тусган 43 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан;
- Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс НДЕГ-ын цахим хуудас болон социал хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын ач холбогдол, үйлчилгээг сурталчилсан богино хугацаат бичлэг 42, постер мэдээлэл 370, контент 16, 2D видео контент 2, 3D видео контент 2, цаг үеийн мэдээ, мэдээлэл 237, шууд дамжуулалт 4 нийт 681 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээн, давхардсан тоогоор 25,191,552 хүнд хүрч 97,115 удаа түгээгдсэн;

- E-Mongolia порталаар дамжуулан даатгуулагч жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон ажилгүйдлийн тэтгэмж, мөн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар гаргах боломжийг бүрдүүлэх зориулалтаар холбогдох 4 төрлийн сервисийг шинээр боловсруулан И-“Монгол академи” УТҮГ-т хүргүүлсэн;
- Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР систем болон нийгмийн даатгалын Portal.ndaatgal.mn веб системээр дамжуулан иргэд, даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн ажилласны үр дүнд мэдээллийн нэгдсэн “SICOS” системээр 259.2 мянган, Portal.ndaatgal.mn системээр 216.2 мянган, нийт 475.5 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, сар бүр 61.9 мянган ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар хүлээн авч 98.0 хувийг шийдвэрлэсэн;
- Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх нийт 153.4 мянган хүсэлтийг хүлээн авч 98.9 хувийг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоолгох, ажилгүйдлийн тэтгэмж тогтоолгох, нийт 230.9 мянган хүсэлтийг хүлээн авч 97.5 хувийг, өндөр нас, ХЧА-ны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр болон тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 80.8 мянган иргэний хүсэлтийг хүлээн авч 96.9 хувийг тус тус шийдвэрлэсэн;
- Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, даатгуулагч, хүнд үзүүлэх эрүүл мэндийн магадлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох, дотоодын хяналтыг эрчимжүүлэх, салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны “Шилдэг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл шалгаруулах” ажлыг зохион байгуулсан;
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу даатгуулагчийн мөнгөжүүлэхээр тооцсон болон мөнгөжүүлэхэд бэлэн орлогын хэмжээг сар бүр тооцоолж, иргэд даатгуулагчид “Нийгмийн даатгал” аппликейшн, Portal.ndaatgal.mn вэб систем, E-Mongolia порталаар авах боломжийг бүрдүүлсэн.
- Шилэн дансны цахим хуудас (Shilen.dans.gov.mn)-т Нийгмийн даатгалын сангийн “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ”, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” төрөлд мэдээлэл байршуулах үйл ажиллагаанд RPA буюу робот процессын автоматжуулалтыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн нэвтрүүлж, туршин ажиллаж байна. Автоматжуулалтыг нэвтрүүлснээр албан хаагчийн өдөрт 1-2 цаг зарцуулж, мэдээлэл байршуулдаг ажиллагааг 58 секундэд хүний оролцоогүйгээр байршуулснаар албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлсэн байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Сангийн сайдын 2025 оны "Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/172 дугаар тушаал;
- Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгаврууд гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

НДЕГ-ын Хяналт, шалгалтын газраас Нийгмийн даатгал болон Нийгмийн хамгааллын чиглэлээр хяналт, шалгалтыг хийсэн байна. Тухайлбал:

Нийгмийн даатгал хяналт, шалгалтын чиглэлээр: Нийгмийн даатгалын хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилт, өмнөх онд хийгдсэн шалгалтын мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилтын хүрээнд нийт 8 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн, дотоод болон гадагшаа чиглэсэн хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэжээ.

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар Тэтгэврийн даатгалын сангаас нэр бүхий 252 иргэдэд тэтгэврийг илүү тооцож олгосон нийт 3,103.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, 216 иргэнд дутуу тооцож олгосон 142.2 сая төгрөгийн нөхөн олгох, баримтын бүрдэл дутуу 119 хүний дутуу бүрдүүлсэн баримтыг нөхөн бүрдүүлэх, хуурамч бичиг баримт бүрдүүлж, үндэслэлгүйгээр тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий 123 хүнтэй холбоотой 3,030.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, нийт төлбөрийн 71.2 хувийг барагдуулсан байна.

НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төвөөс 2023-2025 онд нас барсан тэтгэвэр авагчийн мэдээллийг гаргуулан авч, тэтгэврийн олголтод хийсэн шалгалтаар нийт 721 тэтгэвэр авагч нас барснаас хойш 2,617.5 сая төгрөгийн тэтгэвэр үндэслэлгүйгээр олгогдсоныг тогтоосон байна. Тус шалгалтаар 380 иргэнтэй холбоотой 1,831.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэх нийгмийн даатгалын улсын байцаагчийн акт тогтоон, 233 иргэнд холбогдох 1,129.2 сая төгрөгийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулан тэтгэврийн даатгалын санд нөхөн төлүүлж, 341 иргэнд холбогдох 785.9 сая төгрөгийг эзэн холбогдогчоор нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Нийгмийн хамгааллын хяналт, шалгалтын чиглэлээр: Улсын хэмжээнд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар нийт 132 аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн 6,449.0 сая төгрөгийн өр төлбөрөөс 65 аж ахуйн нэгж, байгууллагын 1,543.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулж ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

НДС-гийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэжээ.

НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны А/243 дугаар тушаалаар баталсан НДС-гийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

НДС-гийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39.7 хувь буюу 980,470.5 сая төгрөгөөр нэмэгджээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	/сая төгрөгөөр/
				1
Мөнгөн хөрөнгө	1,430,750.8	2,255,832.6	825,081.7	
Авлага	726,713.8	868,268.9	141,555.2	
Бараа материал	13,533.0	27,366.5	13,833.6	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	300,000.0	300,000.0	-	
Нийт хөрөнгө	2,470,997.5	3,451,468.0	980,470.5	
Өглөг	37,431.6	76,636.4	39,204.8	
Урьдчилж орсон орлого	51,706.5	69,661.5	17,955.0	
Засгийн газрын хувь оролцоо	2,381,859.4	3,305,170.1	923,310.7	
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,470,997.5	3,451,468.0	980,470.5	

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, Засгийн газрын хувь оролцоо данс байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,255,832.6 сая төгрөг болж, өмнөх оноос 825,081.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,430,750.8	1,340,525.4	(90,225.4)
Төгрөг	1,430,750.8	1,340,501.8	(90,249.0)
Төрийн сангийн харилцах	114,746.8	228,496.1	113,749.4
Арилжааны банк дахь харилцах	1,100,696.9	1,112,005.7	11,308.8
Бусад төсөл, нөөцийн харилцах	215,307.1	-	(215,307.1)
Гадаад валют	-	23.6	23.6
Арилжааны банк дахь харилцах	-	23.6	23.6
Хадгаламж	-	915,307.1	915,307.1
Дүн	1,430,750.8	2,255,832.6	825,081.7
Тэтгэврийн даатгалын сан	361,101.3	596,862.2	235,760.9
Тэтгэмжийн даатгалын сан	327,731.3	258,595.6	(69,135.7)
ҮОМШӨ	484,079.7	338,963.0	(145,116.7)
Ажилгүйдлийн даатгалын сан	4,167.4	2,854.6	(1,312.8)
Эрүүл мэндийн даатгалын сангийн үлдэгдэл	8,116.4	2.6	(8,113.8)
Төвлөрсөн харилцах	30,247.5	55,886.2	25,638.7
Нөөц сангийн харилцах 2025 мөнгөжүүлсэн	215,307.1	87,361.3	(127,945.8)
Хадгаламж	-	700,000.0	700,000.0
Хадгаламж мөнгөжүүлсэн хадгаламж 2025	-	215,307.1	215,307.1
Дүн	1,430,750.8	2,255,832.6	825,081.7

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 825,081.7 сая төгрөгөөр өссөн нь дараах өөрчлөлтөөс голлон шалтгаалжээ. Тухайлбал:

- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулж тэтгэврийн нөөц сантай байхаар заасны дагуу тайлант онд 87,361.3 сая төгрөгийг Худалдаа хөгжлийн банк, ХААН банк, Төрийн банк, Голомт банкин дахь Тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд байршуулж, харилцах дансны үлдэгдлээс тооцогдсон 3 хувийн хүүгийн өгөөж буюу нийт 7,292.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- НДЕГ-ын дэргэдэх МТТ-өөс 1,191,805 даатгуулагчийн 794,843.2 сая төгрөгийг 2024-2025 онуудад мөнгөжүүлэхэд бэлэн орлого болгохоор тооцсоноос 2024 онд 215,307.1 сая төгрөг, тайлант онд 87,361.3 сая төгрөг, нийт 302,668.4 сая төгрөгийг байршуулж, үлдэгдэл 492,174.8 сая төгрөгийг байршуулаагүй байна.
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700,000.0 сая төгрөгөөр тогтоожээ. Уг тогтоолын дагуу ХААН банканд 289,700.0 сая төгрөг, Худалдаа хөгжлийн банканд 176,200.0 сая төгрөг, Голомт банканд 158,400.0 сая төгрөг, Төрийн банканд 75,700.0 сая төгрөгийг 1 жилийн хугацаатай 15.0-15.11 хувийн хүүтэй байршуулж, тайлант онд 70,280.9 сая төгрөгийн хүүгийн өгөөж хүртэн нийгмийн даатгалын сангийн хөрөнгө нэмэгдсэн байна.

СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 181/ШШ2020/02624 дугаар захирамжаар Чингис хаан банк ХХК-иас НДС-д нийт 101,768.2 сая төгрөгийг барагдуулахаар тогтоожээ. Уг захирамжийн дагуу 2021-2025 онд нийт 19,922.9 сая төгрөг барагдуулж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 81,845.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт: НДС-гийн харьяа сангуудад мөнгөн хөрөнгө данстай холбоотой нийт 8,791.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Ажилгүйдлийн тэтгэмжийг 174.2 сая төгрөгөөр илүү олгож авлага үүсгэсэн. /Орхон аймгийн НДС 118.7 сая төгрөг, Төв аймгийн НДС 34.6 сая төгрөг, ЧД-ийн НДС 20.2 сая төгрөг, Дархан-Уул аймгийн НДС 0.7 сая төгрөг/
- Орлого, зардлын дансны бичилтийг буруу хийж нийт 527.3 сая төгрөгөөр бууруулж тайлагнасан. /НД-ийн НДС 0.6 сая төгрөг, СХД-ийн НДС 468.3 сая төгрөг, ХУД-ийн НДС 58.4 сая төгрөг/
- Орлогын төлөвлөгөөг 8,065.7 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн. /Өмнөговь аймгийн НДС 2,720.3 сая төгрөг, Төв аймгийн НДС 2,116.7 сая төгрөг, БНСУ дахь НДТ 3,228.6 сая төгрөг/
- Зөвлөн туслах үйлчилгээний дагуу хийгдсэн ажлуудын гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй, хамрагдалт хангалтгүй, гэрээг дүгнээгүй 9.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. /Говьсүмбэр аймгийн НДС 2.1 сая төгрөг, Ховд аймгийн НДС 7.0 сая төгрөг/
- СБД-ийн НДС нь нийт хөрөнгийн эхний үлдэгдлийг 14.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 868,268.9 сая төгрөг болж, 141,555.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Татаас, санхүүжилтийн авлага	197,631.8	197,239.4	(392.4)
Зээлийн хүүгийн авлага	5,204.6	5,358.0	153.4
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	439,549.6	590,430.6	150,881.0
Бусад авлага	84,327.7	75,241.0	(9,086.7)
Байгууллагаас авах авлага	76,185.6	67,028.0	(9,157.6)
Хувь хүмүүсээс авах авлага	8,142.2	8,213.0	70.9
Дүн	726,713.8	868,268.9	141,555.2

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 141,555.2 сая төгрөгөөр өссөн нь аж, ахуйн нэгж, байгууллагаас авах НДШ-ийн авлага 150,881.0 сая төгрөгөөр нэмэгдэж, Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага 8,130.7 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- НДС-гийн нийт авлагын үлдэгдэл 868,268.9 сая төгрөгийн 68.0 хувь буюу 590,430.6 сая төгрөг нь 40,752 аж ахуйн нэгж, байгууллагаас авах НДШ-ийн авлага эзэлж байгаа бөгөөд тайлант онд авлага өмнөх оноос 150,881.0 сая төгрөгөөр нэмэгджээ.
- УИХ-ын 2020 онд баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль болон Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ын хүрээнд үүссэн ажил олгогч, даатгуулагчийн чөлөөлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэл болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэгийн 197,239.4 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгийн авлагын үлдэгдэл байна;
- НДС-гийн чөлөөт үлдэгдлээс өмнөх онд Засгийн газрын 3 жилийн хугацаатай үнэт цаасыг 300,000.0 сая төгрөгөөр худалдан авсны тайлант хугацааны хүүгийн авлага 5,358.0 сая төгрөг;

- Байгууллагаас авах нийт 67,028.0 төгрөгийн авлагын үлдэгдлийн 85.9 хувь буюу 57,570.9 сая төгрөгийг Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага эзэлж байна. Тайлант хугацаанд тус банкны эрх хүлээн авагчаас өмнөх оны авлагын үлдэгдэл 65,701.6 сая төгрөгөөс нийт 8,130.7 сая төгрөгийг барагдуулснаас 1,600.0 сая төгрөг нь мөнгөн хөрөнгөөр, 6,530.7 сая төгрөгийн орон сууц, авто зогсоолын зориулалттай 11 үл хөдлөх хөрөнгө байна;
- Хувь хүмүүсээс авах авлага 1,137.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,066.7 сая төгрөгөөр буурч нийт 8,213.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны авлагаас барагдаагүй үлдэгдэлтэй хэвээр байна. Уг авлагын үлдэгдэлд НДС-гийн харьяа 30 сангийн 7,894.0 сая төгрөг, нийгмийн даатгалын ерөнхий газрын төв сангийн 318.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна;
- СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 181/ШШ2024/00464 дугаар захирамжаар тогтоосон Чингис хаан банканд байршиж буй дансны үлдэгдэлд тооцсон (2020 оны 08,09,10 саруудад) хүүгийн авлагын 1,801.9 сая төгрөгийг төлбөр барагдуулах дараалал хүлээгдэж байгаагаас шалтгаалан барагдаагүй байна. Тайлант онд мөнгөн хөрөнгөөр 4,061.2 сая төгрөг болон оффис, орон сууцны зориулалттай 7,492.7 сая төгрөгийн өртөгтэй 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авч, нийт 11,553.9 сая төгрөгийн авлагыг барагдуулжээ.

Аудитын илрүүлэлт: НДС-гийн харьяа сангуудын авлага данстай холбоотой нийт 98,234.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өмнөх оны үлдэгдэл 65,701.6 сая төгрөгийн авлагаас 12.4 хувь буюу 8,130.7 сая төгрөгийг барагдуулж, 57,570.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, олон жилийн насжилттай өмнөх оны үлдэгдэл 6,444.8 сая төгрөгийн авлагаас 9.8 сая төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 6,434.9 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулаагүй;
- Өмнөговь аймгийн НДС-гийн авлагын үлдэгдэл тайлант онд нийт 32,475.6 сая төгрөг болж, өмнөх оноос 7,639.2 сая төгрөгөөр өссөн байна;
- Нэг жилээс дээш насжилттай нийт 610.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй; /Архангай аймгийн НДС 12.3 сая төгрөг, Дорнод аймгийн НДС нь 598.0 сая төгрөг/
- Тайлант онд 1,098.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй; /НД-ийн НДС 130.0 сая төгрөг, СХД-ийн НДС 110.7 сая төгрөг, СБД-ийн НДС 802.0 сая төгрөг, ЧД-ийн НДС 56.0 сая төгрөг/
- Эзэн холбогдогч тодорхойгүй 44.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. / БНСУ дахь НДТ 16.8 сая төгрөг, СБД-ийн НДС 27.6 сая төгрөг/

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 27,366.5 сая төгрөг болж, өмнөх оноос 13,833.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Бэлэн бүтээгдэхүүн	13,533.0	27,366.5	13,833.6
Дүн	13,533.0	27,366.5	13,833.6

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бэлэн бүтээгдэхүүн дансанд нийт 27,366.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлагад тооцон 27 ширхэг нийт 19,873.8 сая төгрөгийн үйлдвэр, үйлчилгээ, оффис, орон сууцны зориулалттай хөрөнгө, болон Чингис хаан банкнаас 2024, 2025 онд шилжүүлэн авсан 11 ширхэг 7,492.7 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж авсныг бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,833.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Капитал банкны эрх хүлээн авагчаас 6,530.7 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, болон Чингис Хаан банкнаас 7,492.7 сая төгрөгийн хөрөнгүүдийг авлагад тооцуулан шилжүүлэн авч, 189.8 сая төгрөгийн 1 үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулан данснаас хассантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материал данстай холбоотой нийт 27,366.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Капитал банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банкнаас 2021-2025 онд авлагад тооцуулан хүлээн авсан нийт 27,366.5 сая төгрөгийн 38 ширхэг үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байгаагаас тайлант онд дээрх хөрөнгөтэй холбоотой ашиглалтын зардалд нийт 76.8 сая төгрөгийг зарцуулсан.
- Өмнөх онд 2,642.1 сая төгрөгийн хөрөнгийг борлуулж байсан бол тайлант онд 189.8 сая төгрөгийн орон сууцны зориулалттай 1 үл хөдлөх хөрөнгийг борлуулж, өмнөх оноос 92.3 хувиар буурсан нь авлагад тооцож авсан хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажил удаашралтайг харуулж байгаагаас гадна жил ирэх бүр хөрөнгийн үнэ цэн буурч, авлагын үлдэгдэл бүрэн барагдахгүй байх, ашиглалтын зардал нэмэгдэх эрсдэлтэй байна.

3.4.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 300,000.0 сая төгрөг байна.

Хүснэгт 6. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Үнэт цаас	300,000.0	300,000.0	-
Дүн	300,000.0	300,000.0	-

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 300,000.0 сая төгрөг нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹, 13.1.1² дэх заалтуудыг үндэслэн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн баталсан 14 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсны дагуу “Засгийн газрын дотоод үнэт цаас худалдах, худалдан авах” 2024 онд 199/НД73/24 дугаартай гэрээг Сангийн яамтай 3 хүртэл жилийн хугацаатай нийт 55,000.0 сая төгрөгийн хүүгийн өгөөж хүртэхээр байгуулж, НДС-аас 300,000.0 сая төгрөгийн Засгийн газрын үнэт цаас худалдан авсан өмнөх оны үлдэгдэл байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 146,298.0 сая төгрөг болж, 57,159.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,138.1	146,298.0	57,159.8
Өглөг	37,431.6	76,636.4	39,204.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.1	0.2	0.1
Зээлийн хүүгийн өглөг	-	20.4	20.4
Бусад өглөг	37,431.5	76,615.9	39,184.4
Байгууллагад төлөх өглөг	10,698.8	10,347.7	(351.1)
Хувь хүмүүст төлөх өглөг	25,834.2	65,393.8	39,559.6
Дансны өглөг /ТӨҮГ/	898.5	874.4	(24.1)
Урьдчилж орсон орлого	51,706.5	69,661.5	17,955.0
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	51,706.5	69,661.5	17,955.0
Дүн	89,138.1	146,298.0	57,159.8

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

¹ Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно:

² Засгийн газрын үнэт цаас;

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 57,159.8 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн ерөнхий газарт төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 7,742.5 сая төгрөгийн өглөг, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 159,333.3 сая төгрөг төвлөрч, төлөвлөснөөс 3,327.2 сая төгрөгөөр тасарснаас шалтгаалан хувь хүмүүст өгөх өглөг 39,184.4 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлжээ.

Урьдчилж орсон орлого дансанд сайн дурын даатгуулагч, ажил олгогч, улсын төсвөөс хариуцан төлдөг малчин, туслах малчин болон 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг урьдчилж төлсөн нийт 69,661.5 тэрбум төгрөг бүртгэлтэй байна.

Цар тахал буюу коронавируст халдвар тархсан онцгой нөхцөл байдлын үед аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийг дэмжих зорилгоор УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйл³, ЗГ-ын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын дагуу ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлсэн 706,616.0 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг бууруулж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт: НДС-гийн харьяа сангуудад өр төлбөрийн данстай холбоотой нийт 558.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- СБД-ийн НДС-нд 29.6 сая төгрөгийн эзэн холбогдогчгүй өглөг бүртгэлтэй;
- Төв аймгийн НДС нь тайлант онд 342.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн;
- Олон жилийн насжилттай 186.7 сая төгрөгийн өглөгийг буцаан олгох арга хэмжээ аваагүй. /Булган аймгийн НДС 16.6 сая төгрөг, БГД-ийн НДС 49.9 сая төгрөг, БЗД-ийн НДС 16.3 сая төгрөг/

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,305,170.1 сая төгрөг болж, өмнөх оноос 923,310.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+) Бууралт (-)	
Хуримтлагдсан үр дүн	2,381,859.4	3,305,170.1	923,310.7	
Өмнөх үеийн үр дүн	1,875,483.3	2,379,871.9	504,388.6	
Тайлант үеийн үр дүн	506,376.1	925,298.1	418,922.1	
Дүн	2,381,859.4	3,305,170.1	923,310.7	

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 923,310.7 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнгээс голлон шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан.

³ 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 2, 4, 5 дахь хэсэгт заасан сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын болон нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

НДЕГ-аас Сангийн яамны “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж, маягт”-ын дагуу Нийгмийн даатгалын сангийн нийт орлогыг 4,799,030.7 сая төгрөг, нийт зарлагыг 6,025,145.0 сая төгрөг, алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс олгох татаас 1,226,114.3 сая төгрөгөөр тооцон боловсруулж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн Гэр, бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлжээ.

НДС-гийн нийт орлогыг ажил олгогч аж ахуйн, нэгжээс төлөх шимтгэл 2,500,971.0 сая төгрөг, даатгуулагчаас 1,975,686.8 сая төгрөг, эхийн хүүхдээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн даатгалын сангаас төлөх 7,271.6 сая төгрөг, улсын төсвөөс төлөх 6,798.3 сая төгрөг, малчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа эцэг, эхийн улсын төсвөөс төлөх шимтгэл 37,258.1 сая төгрөг, цаатан иргэдийн иргэдийн шимтгэл 146.6 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас төлөх 210,133.3 сая төгрөг, БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн шимтгэл 5,201.7 сая төгрөг, ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн төлөх шимтгэл 2,337.4 сая төгрөг, малчин, ХХЭ-ийн нөхөн даатгал 16,485.5 сая төгрөг, бусад орлогоос 36,740.6 сая төгрөг, нийт 4,799,030.7 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

НДС-гийн нийт зарлагыг 6,025,145.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс тэтгэврийн даатгалын сан 5,533,343.2 сая төгрөг, тэтгэмжийн сан 281,082.7 сая төгрөг, ажилгүйдлийн сан 142,985.3 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 67,733.8 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төсвийг боловсруулжээ.

УИХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар НДС-гийн 2025 оны төсвийн тухай хуульд нийт орлогыг 6,908,073.9 сая төгрөг, (үүнд төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас 1,452,499.9 сая төгрөг ороод), нийт зарлагыг 5,869,455.9 сая төгрөг байхаар баталжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах” шаардлагаар нийцүүлэн төсвийг боловсруулахаар төсөвт бүхэлд нь хориг тавьсны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хоригийг хэлэлцэж, 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоомжийг хүчингүй болгосон байна.

УИХ-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар НДС-гийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийт орлогыг 19,129.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 6,927,203.2 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2⁴, 34.1.4⁵-т заасан төсөвт тодотгол хийх нөхцөл бүрдсэн тул Монгол Улсын Засгийн газраас НДС-гийн 2025 оны төсвийн тухай хуульд 2 дахь удаа өөрчлөлт оруулж, УИХ-ын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар нийт орлогыг 19,129.3 сая төгрөгөөр бууруулан 6,908,073.9 сая төгрөг, нийт зарлагыг 5,869,455.9 сая төгрөгөөр тус тус баталжээ.

⁴ урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;

⁵ төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

НДС-д ажил олгогчийн төлөх шимтгэл 2,823,802.0 сая төгрөг, ажиллагчдаас төлөх шимтгэл 2,277,507.1 сая төгрөг, эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл 14,543.1 сая төгрөг, цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл 146.6 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл 294,322.0 сая төгрөг, гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл 6,158.8 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл 2,353.8 сая төгрөг, бусад орлого 36,740.6 сая төгрөг, төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас 1,452,499.9 сая төгрөг, нийт 6,908,073.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр, нийт зарлагыг 5,869,455.9 сая төгрөг буюу тэтгэврийн даатгалын сангаас 5,360,537.4 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 280,490.8 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 66,550.9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 161,876.8 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталжээ.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2024 оны гүйцэтгэл	2025 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1.1	Ажил олгогчийн төлөх шимтгэл	2,457,521.6	2,823,802.0	2,765,986.4	(57,815.7)	98.0
1.2	Ажиллагчдаас төлөх шимтгэл	1,757,781.3	2,277,507.1	2,138,084.6	(139,422.6)	93.9
1.3	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	11,615.7	14,543.1	10,205.4	(4,337.7)	70.2
1.4	Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	237.9	146.6	146.6	-	100.0
1.5	Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	172,876.6	294,322.0	188,284.8	(106,037.2)	64.0
1.6	Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	1,447.6	6,158.8	1,144.7	(5,014.1)	18.6
1.7	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,817.9	2,353.8	1,607.5	(746.3)	68.3
1.8	Бусад орлого	31,389.5	36,740.6	126,475.4	89,734.7	344.2
1.9	Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	1,174,974.0	1,452,499.9	1,452,499.9	-	100.0
1.1	ЭМД-ын сангаас санхүүжих	-	-	-	-	-
Нийгмийн даатгалын сангийн орлогын дүн		5,609,662.0	6,908,073.9	6,684,435.1	(223,638.8)	96.8
Нийгмийн даатгалын сангийн зардал, сан тус бүрээр						
1	Тэтгэврийн даатгалын сан	4,666,516.4	5,360,537.4	5,341,198.8	(19,338.6)	99.6
2	Тэтгэмжийн даатгалын сан	256,284.0	280,490.8	291,584.2	11,093.4	104.0
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	48,130.0	66,550.9	52,062.5	(14,488.4)	78.2
4	Ажилгүйдлийн даатгалын сан	136,274.7	161,876.8	163,671.4	1,794.6	101.1
Нийгмийн даатгалын сангийн зардлын дүн		5,107,205.1	5,869,455.9	5,848,516.9	(20,939.0)	99.6

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу ТЕЗ-ийн харьяа сангуудтай холбоотой 2 төрлийн судалгаа авч үр дүнг нэгтгэн, аудитын тайланд тусгалаа. Үүнд:

- Сургалт, семинарын талаар: Тайлант онд 4 сургалт, семинарын зардалд нийт 45.8 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 4 сургалт зохион байгуулахад 45.8 сая төгрөгийг зарцуулсан байна.
- НДС-гийн үйл ажиллагааг ярилцлага, мэдээ тодруулга, сурвалжлаг видео контент постер хэлбэрээр олон нийтэд сурталчлах зардалд нийт 172.9 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 24 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, 172.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт

Хүснэгт 10. Нийгмийн даатгалын нийт орлого

/сая төгрөгөөр/

Нийгмийн даатгалын сан	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	2025 он		Зөрүү
			Гүйцэтгэл	Хувь	
Тэтгэвэр	3,573,080.8	4,606,115.3	4,239,834.9	92.0	(366,280.3)
Тэтгэмж	382,362.9	414,546.6	479,506.0	115.7	64,959.5
ҮОМШӨ	339,845.8	272,251.7	353,261.0	129.8	81,009.3
Ажилгүйдэл	139,398.6	162,660.6	159,333.3	98.0	(3,327.2)
УТ-ийн дэмжлэг	1,174,974.0	1,452,499.9	1,452,499.9	100.0	-
Нийт орлого	5,609,662.0	6,908,073.9	6,684,435.1	96.8	(223,638.8)

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд тэтгэмжийн даатгалын сангийн орлогыг 15.7 хувь буюу 64,959.5 сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлогыг 29.8 хувь буюу 81,009.3 сая төгрөгөөр тус тус давж, тэтгэврийн даатгалын сангийн орлогыг 8.0 хувь буюу 366,280.3 сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг 3,327.2 сая төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 5,869,455.9 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 99.6 хувь буюу 5,848,516.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 11. Нийгмийн даатгалын нийт зарлага

/сая төгрөгөөр/

Нийгмийн даатгалын сангийн төрөл	2024 оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	2025 он		Зөрүү
			Гүйцэтгэл	Хувь	
Тэтгэвэр	4,666,516.4	5,360,537.4	5,341,198.8	99.6	(19,338.6)
Тэтгэмж	256,284.0	280,490.8	291,584.2	104.0	11,093.4
ҮОМШӨ	48,130.0	66,550.9	52,062.5	78.2	(14,488.4)
Ажилгүйдэл	136,274.7	161,876.8	163,671.4	101.1	1,794.6
Нийт зарлага	5,107,205.1	5,869,455.9	5,848,516.9	99.6	(20,939.0)

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

НДС-гийн зардал өмнөх оноос 741,311.8 сая төгрөгөөр өссөн байна. Тухайлбал:

- ЗГ-ын “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 6.0 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоожээ. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж, тэтгэврийн нэмэгдэлд 300,100.0 сая төгрөгийг зарцуулсан байна.
- НДС-аас тэтгэвэр, тэтгэмж авагч өмнөх оноос 54.3 мянган иргэнээр нэмэгдэн нийт 838,868 даатгуулагч болж сангийн зардал 441,211.8 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд НДС-д нийт 6,684,435.1 сая төгрөгийн орлого төвлөрснөөс НДШ-ийн орлого 78.3 хувь буюу 5,231,935.2 сая төгрөг, улсын төсвөөс олгосон татаас 21.7 хувь буюу 1,452,499.9 сая төгрөг, гүйцэтгэлээр нийт 5,848,516.9 сая төгрөгийг зарцуулж, 835,918.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын санд НДШ-ийн 4,239,834.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 5,341,198.8 сая төгрөгийг зарцуулж, үүнээс 1,101,363.9 сая төгрөгийн алдагдлыг улсын төсвөөс олгосон татаасаар 1,447,421.9 сая төгрөгөөр санхүүжүүлж, тус сан 346,058.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй;

- Тэтгэмжийн даатгалын санд 479,506.0 сая төгрөгийн орлого төвлөрч, 291,584.2 сая төгрөгийг зарцуулж, 187,921.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 353,261.0 сая төгрөгийн орлого төвлөрч, улсын төсвөөс олгосон татаас 5,078.0 сая төгрөг төвлөрч, нийт 52,062.5 сая төгрөгийг зарцуулж, 306,276.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Ажилгүйдлийн даатгалын санд 159,333.3 сая төгрөгийн орлого төвлөрч, 163,671.4 сая төгрөгийг зарцуулж, 4,338.0 сая төгрөгийн алдагдалтай байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд⁶ НДС-гийн зарлагыг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээнд зарцуулахаар заасны дагуу тус сангийн хөрөнгөөс дараах 3 худалдан авалтыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулжээ. Үүнд:

1. Нийгмийн даатгалын багц хууль, холбогдох журам, дүрэм, зааврын эмхэтгэл бэлтгэх, түгээх 42.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй (тендерийн дугаар: НДЕГ/20250201007/) худалдан авалтыг зохион байгуулж, шалгарсан “Адмон принт” ХХК-тай гэрээ байгуулан тараах материал хүлээн авч, гэрээний дагуу 41.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
2. ҮОМШӨ-ний шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажлыг зохион байгуулах 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй (тендерийн дугаар: НДЕГ/20250103009/) худалдан авалтыг зохион байгуулж, шалгарсан “Эм Эм Си Жи” ХХК-тай гэрээ байгуулж, 96.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
3. НДС-аас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн ач холбогдлыг сурталчилсан маркетингийн бүтээгдэхүүн бэлтгэх, олон нийтэд түгээх 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй (тендерийн дугаар: НДЕГ/20250201008/) худалдан авалтыг зохион байгуулж, тендерт оролцогч мэдээлэл ирүүлээгүйн улмаас амжилтгүй болсон байна.

3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус ГБХНХС-ын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

Хүснэгт 12. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч	Хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны зорилтот түвшин	2025 оны хүрсэн түвшин
31.1	71901 Нийгмийн даатгал					
	31.1.1	Нийгмийн даатгалын ач	Албан журмын даатгуулагчийн ажиллагсдын тоонд эзлэх хувь	Хувь	93.4	91.2

⁶ 12.1.6.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	холбогдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь	Хувь	61.8	62.7
		Малчдын сайн дурын даатгалд хамрагдах хувь	Хувь	24.0	24.0

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ 2025 оны жилийн эцсийн байдлаар албан журмын даатгуулагчийн ажиллагсдын тоонд эзлэх хувь 91.2 болж, албан журмын даатгуулагчдын тоо 1,180,500, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь 62.7 болж, 63,700, малчдын сайн дурын даатгалд хамрагдсан хувь 24.0 болж, нийгмийн даатгалд хамрагдсан малчдын тоо 56,500-д тус тус хүрсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн НДС-гийн үйл ажиллагааг сайжруулах, олон жилийн насжилт өндөртэй авлага, өглөгийг барагдуулах, нийгмийн даатгалын нэгдсэн системийн сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөхжаргал, Д.Номингуа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/920 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны зардал болон үйл ажиллагааны бус зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардал болон үйл ажиллагааны бус зардал нийт 5,164,457.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 51,644.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15,688,347.9 сая төгрөгийн 23,507 гүйлгээг, зарлагын 14,653,527.3 сая төгрөгийн 6,317 гүйлгээг, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслахтай холбоотой 73 тушаал, шийдвэрийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Төсвийн ерөнхийлөн захирагч:

Албан шаардлага

1) НДЕГ, Цагдаа, Эрүүл мэндийн байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоо хангалтгүй, Нийгмийн даатгалын тухай ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, энэ талаар журам, заавраар тусгайлан зохицуулаагүй байна. Үүнээс шалтгаалан НДЕГ-ын Хяналт, шалгалтын газраас хийсэн шалгалтаар иргэд нас барсан даатгуулагчийн тохиолдлыг бүртгүүлдэггүйгээс 2023-2025 оны хооронд 721 иргэнд нийт 2,617.5 сая төгрөгийн тэтгэвэр олгосон зөрчил илэрсэн нь дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т "Нийгмийн даатгалын байгууллага мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, хүнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалт хийх зорилгоор төрийн бусад байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг ашиглана.", Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.2-т "тэтгэвэр авагчийг нас барсны дараагийн сарыг дууссан өдрөөс, эсхүл тэтгэвэр авагчийг сураггүй алга болсныг тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн ерөнхий газар болон бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоо хангалтгүй, хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

Илрүүлэлт 01:

1. Тайлант оны байдлаар НДС-д байгууллагаас авах нийт 590,430.6 сая төгрөгийн НДС-ийн авлага бүртгэлтэй байгаагаас 1,000.0 сая төгрөгөөс дээш 79 аж, ахуйн нэгж, байгууллага нийт 197,488.9 сая төгрөгийн НДС-ийн авлагатай байна. Тухайлбал: 4-5 жилийн насжилттай 18,367.3 сая төгрөгийн өртэй 1 аж ахуйн нэгж, 1-2 жилийн насжилттай 11,253.8 сая төгрөгийн өртэй 1 аж ахуйн нэгж, 1 жилийн насжилттай 9,628.4 сая төгрөгийн өртэй 1 аж ахуйн нэгж, 3-4 жилийн насжилттай 7,742.2 сая төгрөгийн өртэй 1 аж ахуйн нэгж, 2-3 жилийн насжилттай 3,457.6-3,794.3 сая төгрөгийн өртэй 3 аж ахуйн нэгж, 4-5 жилийн насжилттай 2,031.0-2,962.7 сая төгрөгийн өртэй 22 аж ахуйн нэгж, 5 хүртэлх жилийн насжилттай 1,002.7-1,944.7 сая төгрөгийн өртэй 22 аж ахуйн нэгж байна.

2. Аж ахуйн нэгжүүд НДС-ийн төлөлтийг тухай бүр төлөөгүйгээс орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөхөөс гадна даатгуулагчийн эрх зөрчигдөх, тусламж, үйлчилгээ авч чадахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө.", 44 дүгээр зүйлийн 44.1.2-т "төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар, эсхүл эрх бүхий байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй, дутуу төлсөн бол хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги тооцно. Алдангийн хэмжээ нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна." заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгж, байгууллагын хуримтлагдсан олон жилийн насжилттай НДС-ийн авлагыг эрчимтэй бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авах.

Илрүүлэлт 02:

Тайлант онд хувь хүмүүсээс авах авлага 1,137.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,066.7 сая төгрөгөөр буурч нийт 8,213.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны авлагаас барагдуулалт хийгдээгүй үлдэгдэлтэй хэвээр байгаа нь нийгмийн даатгалын улсын байцаагчийн тогтоосон актын олон жилийн насжилттай, эзэн холбогдогч тодорхойгүй, нас барсан даатгуулагчийн авлагын үлдэгдлийн барагдуулалт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг

сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүмүүсээс авах олон жилийн насжилттай авлагыг эрчимтэй бууруулах ажлыг зохион байгуулж ажиллах.

Илрүүлэлт 03:

Харьяа 33 сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн аудиттай холбоотой нийт 27,366.5 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан 2 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн, бусад хууль тогтоомжтой холбоотой 27,366.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төсвийн ерөнхийлөн захирагчаас хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-т "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;" , 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа сангуудын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтыг хангалттай хэрэгжүүлэх, хөрөнгийг удирдлагыг үр дүнтэй зохион байгуулах.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төв сан:

Албан шаардлага:

1) 1. Капитал банкны эрх хүлээн авагч болон Чингис Хаан банкнаас СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 181/ШШ2020/02624 дүгээр захирамж, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 182/ШШ2020/02419 дүгээр захирамжийн дагуу 2021-2025 онд авлагад тооцуулан хүлээн авсан нийт 27,366.5 сая төгрөгийн 38 ширхэг үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байгаагаас тайлант онд дээрх хөрөнгөтэй холбоотой ашиглалтын зардалд нийт 76.8 сая төгрөгийг зарцуулсан.

2. Өмнөх онд 2,452.3 сая төгрөгийн хөрөнгийг борлуулж байсан бол тайлант онд 189.8 сая төгрөгийн орон сууцны зориулалттай 1 үл хөдлөх хөрөнгийг борлуулж, өмнөх оноос 92.3 хувиар буурсан нь авлагад тооцож авсан хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажил удаашралтайг харуулж байгаагаас гадна жил ирэх бүр хөрөнгийн үнэ цэн буурч, авлагын үлдэгдэл бүрэн барагдахгүй байх, ашиглалтын зардал нэмэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 5.1.5-д "хариуцлагатай байх.", 41 дүгээр зүйлийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг

хүлээнэ: 41.2.1. хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх," Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Капитал банкны эрх хүлээн авагч болон Чингис Хаан банкнаас авлагад тооцуулан хүлээн авсан хөрөнгийг худалдан борлуулах зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг:

Зөвлөмж:

Илрүүлэлт 04:

Төрийн аудитын байгууллагад 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-т заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-ийн 54.5.4-т "өр төлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, нэмэлт төсвийн гүйцэтгэл, хүрсэн үр дүн, тэдгээрийн танилцуулгыг бэлтгэж төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн тайлагнаж Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх.

4.4.3 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,035,010.4 сая төгрөгийн 13 зөрчил илэрснээс, 887,503.7 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 9,424.4 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцуулах албан шаардлага, 138,082.3 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс аудитын шийдвэрийн дундаж хэрэгжилт 80.6 хувьтай байна.

Хүснэгт 13. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Биелээгүй		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	7	887,503.7	3	686,928.9	4	200,574.8	77.4
Хариуцлага тооцох албан шаардлага	1	9,424.4	1	9,424.4	-	-	100.0
Зөвлөмж	5	138,082.3	5	138,082.3	-	-	100.0
Нийт дүн	13	1,035,010.4	9	834,435.6	4	200,574.8	80.6

Өмнөх оны аудитаар өгсөн дараах аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Чингис хаан банканд байршиж буй НДС-гийн мөнгөн хөрөнгийн өмнөх оны үлдэгдэл 93,399.2 сая төгрөгөөс тайлант онд 12.4 хувь буюу 11,553.9 сая төгрөгийг мөнгөн

хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авч 81,845.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тус сангаас барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч бүрэн барагдаагүй тул авлагыг бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн;

- Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өмнөх оны үлдэгдэл нийт 65,701.6 сая төгрөгийн өмнөх оны авлагаас 12.4 хувь буюу 8,130.7 сая төгрөгийг мөнгөн хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авч авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажилласан боловч 57,570.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй хэвээр байгаа тул авлагыг эрчимтэй бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн;
- Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах өмнөх оны 6,444.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс тайлант онд дампуурсан ХОТШ банк нийт 9.8 сая төгрөгийн авлага барагдуулж, хууль хяналтын байгууллагад хандан арга хэмжээ авч ажилласан боловч нийт 6,345.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа тул авлагыг эрчимтэй бууруулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн;
- Капитал банкны эрх хүлээн авагчаас авлагад тооцуулан авсан нийт 13,533.0 сая төгрөгийн хөрөнгөөс өмнөх онд 2,452.3 сая төгрөгийн хөрөнгийг борлуулж байсан бол тайлант онд 189.8 сая төгрөгийн орон сууцны зориулалттай 1 үл хөдлөх хөрөнгийг борлуулж, өмнөх оноос 92.3 хувиар буурсан нь байна. Аудитаар хөрөнгийг худалдан борлуулах ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 75 дугаар захирамжаар “Төлбөрийн чадваргүйн улмаас санхүүгийн эрсдэлд орсон, татан буугдсан банканд байршиж байсан тусгай зориулалтын сан, төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг буцаан төвлөрүүлж, төрийг хохиролгүй болгох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулагдан НДЕГ-ын төлөөлөл оролцон ажиллаж, тайлант онд нийт 19,694.4 сая төгрөгийн авлагыг барагдуулжээ.

4.4 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах дараах асуудлуудын авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд бодит цагийн горимд ажиллах мэдээллийн нэгдсэн систем “SICOS”, мөн иргэд даатгуулагч, ажил олгогчид зориулсан “Иргэний болон ажил олгогчийн портал систем /Portal.ndaatgal.mn/”-ийг 2024 оноос эхлэн нэвтрүүлэн ажиллаж байна. Тус “SICOS” мэдээллийн нэгдсэн системээр даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмжийг үнэн зөв, зохистой олгогдож байгаа эсэх болон бусад холбогдох төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлын уялдаа холбооны талаар дараагийн аудитаар горим, сорил хэрэгжүүлэх;
- Капитал банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банк ХХК-ас 2021-2025 онд авлагад тооцуулан хүлээн авсан нийт 27,366.5 сая төгрөгийн 38 ширхэг үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байгаа бөгөөд борлуулагдаагүй үлдсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдалд биет горим, сорил хэрэгжүүлэх;
- Тайлант онд нийгмийн даатгалын улсын байцаагчийн хяналт, шалгалтаар илрүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу тооцсон 171.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн алданги 77.6 сая төгрөгийн зөрчилд өгсөн шийдвэрийн хэрэгжилт, алданги, торгуулийн орлогын бүртгэл, тайлагналд горим сорил хэрэгжүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа⁷ илэрснийг аудитын явцад залруулав.

НДС-гийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 169,121.4 сая төгрөгийн 49 зөрчил⁸ илэрснээс, 0.7 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 158,688.7 сая төгрөгийн 14 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10,431.9 сая төгрөгийн 34 зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт 169,121.4 сая төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 117,476.8 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний сангуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 27 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа сангуудын 27 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 21,468.4 сая төгрөгийн 45 зөрчил илэрснээс 0.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 11,035.7 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 10,431.9 сая төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж өгсөн.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч:

Аудитаар нийт 147,653.0 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 147,653.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.2.1. Албан шаардлага

1. Чингис хаан банканд байршиж буй Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн өмнөх оны үлдэгдэл 93,399.2 сая төгрөгөөс тайлант онд 12.4 хувь буюу 11,553.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч (үүнээс 4,061.2 сая төгрөг нь мөнгөн хөрөнгөөр, 7,492.7 сая төгрөгийн өртөгтэй оффис, орон сууцны зориулалттай 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авсан байна) 81,845.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. СБД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд дансны үлдэгдлийн баталгаа гаргаж баталгаажуулсан боловч уг хөрөнгийг банкнаас бүрэн гаргах боломжгүй бодит бус үлдэгдэлтэй хэвээр байна.

2. Шүүхийн шийдвэрийн дагуу тус банканд байршиж буй дансны үлдэгдэлд тооцсон /2020 оны 08,09,10 саруудад/ хүүгийн авлагын 1,801.9 сая төгрөгийг төлбөр барагдуулах дараалал хүлээгдэж байгаагаас шалтгаалан барагдаагүй үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" , 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." , 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

⁷ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁸ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд төвлөрүүлэх ажил удаашралтай, 2020 оны шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өмнөх оны үлдэгдэл нийт 65,701.6 сая төгрөгийн авлагаас 12.4 хувь буюу 8,130.7 сая төгрөгийн хөрөнгө (үүнээс 1,600.0 сая төгрөг нь мөнгөн хөрөнгөөр, 6,530.7 сая төгрөгийн орон сууц, авто зогсоолын зориулалттай 11 үл хөдлөх хөрөнгө) барагдаж, нийт 57,570.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Капитал банкны эрх хүлээн авагчаас авах нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 57,570.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг тус банкны эрх хүлээн авагчтай хамтран эрчимжүүлэх, албан шаардлага хүргүүлэв.

3. Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах өмнөх оны 6,444.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс тайлант онд дампуурсан ХОТШ банк 9.8 сая төгрөгийн авлага барагдуулж, нийт 6,435.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, хууль хяналтын байгууллагад хандан арга хэмжээ авч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Дампуурсан болон татан буугдсан 7 банкны нийт 5,436.3 сая төгрөгийн авлага /Сэргээн босголт банк 2,066.6 сая төгрөг, ХОТШ банк 1,572.4 сая төгрөг, Монгол даатгал-Ардын банк 824.5 сая төгрөг, Экзим банк 753.2 сая төгрөг, Монгол бизнес банк 200.0 сая төгрөг, Азийн хөрөнгө оруулалтын банк 19.6 сая төгрөг/;
- 16 аж ахуй нэгжийн НДШ-ийн 909.8 сая төгрөгийн авлага /Тухайлбал: Нийслэлийн өмчийн газар 552.6 сая төгрөг, "Өндөр гэгээн" ХХК 111.7 сая төгрөг/;
- 15 иргэний НДШ-ийн 88.9 сая төгрөгийн авлага тус тус байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлагыг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

Илрүүлэлт 01:

Харьяа 33 сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,469.8 сая төгрөгийн 47 алдаа, зөрчил илэрснээс 1.4 сая төгрөгийн 2 алдааг залруулга хийлгэж, 21,468.4 сая төгрөгийн 45 зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-т "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-т "Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:, 37.13.5-д "нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулан гүйцэтгэх.

5.3 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагад илэрсэн алдаа, зөрчил

5.3.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төв сан:

Албан шаардлага

1. ҮОМШӨ-ний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх ажиллагааны зардалд анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй 48.7 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3.2 БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг:

Зөвлөмж

Илрүүлэлт 01:

1. Бусад авлагын дансанд 16.8 сая төгрөг, бусад өглөгийн дансанд 11.5 сая төгрөгийн эзэн холбогдогчгүй буюу валютын ханшийн олз, гарзын зөрүүг бүртгэж тайлагнасан нь НДС-гийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу бүртгэж тайлагнаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “нягтлан бодох бүртгэл үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил үйлчилгээ гаргасан нь мөнгө хүлээн авсан эсэхийг баталгаажуулах” гэж заасан үүргийг хэрэгжүүлээгүй бөгөөд “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж, мэдээллээр хангах шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эзэн холбогдогчгүй, авлага, өглөг болон валютын ханшийн олз, гарзын зөрүүг НДС-гийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасны дагуу бүртгэж тайлагнах.

2. Тайлант оны орлогын төлөвлөгөөг 3,228.6 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн. Үүнд: Тэтгэврийн даатгалын шимтгэл 2,323.1 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 455.8 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг 449.7 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;”, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 11.1.1.даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл; 11.1.2.ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй боловсруулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	Говьсүмбэр аймгийн НДС	1	-			1	-	1	-				
2	Хөвсгөл аймгийн НДС	1	1,394.6			1	1,394.6	1	1,394.6				
	АЛДААНЫ ДҮН	2	1,394.6	-	-	2	1,394.6	2	1,394.6	-	-	-	-

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Үүнээс:								тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
		Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн								
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
I. Төсвийн ерөнхийлөн захирагч																	
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга	1		1				4	147,652,981.5			3	147,652,981.5			1	-
	Дүн	1	-	1	-	-	-	4	147,652,981.5	-	-	3	147,652,981.5	-	-	1	-
II. Засгийн газрын тусгай сан																	
1	Архангай НДС	1	1					1	12,290.5			1	12,290.50				
2	Баянхонгор НДС	1	1					-	-								
3	Баян-Өлгий НДС	1	1					-	-								
4	Булган НДС	1	1					2	39,281.5							2	39,281.5
5	Говь-Алтай НДС	1					1	0	-								
6	Говьсүмбэр НДС	1	1					2	290,741.7							2	290,741.7
7	Дархан-Уул НДС	1	1					1	733.7	1	733.7						
8	Дорнод НДС	1	1					1	597,996.3			1	597,996.3				
9	Дорноговь НДС	1					1	-	-								
10	Дундговь НДС	1					1	-	-								
11	Завхан НДС	1	1					-	-								
12	Орхон НДС	1	1					3	118,744.9			1	5,412.6			2	113,332.3
13	Өвөрхангай НДС	1	1					-	-								
14	Өмнөговь НДС	1	1					2	10,359,513.5			1	7,639,169.4			1	2,720,344.1
15	Сүхбаатар НДС	1	1					-	-								
16	Сэлэнгэ НДС	1	1					1	1,290,243.9			1	1,290,243.9				
17	Төв НДС	1	1					3	2,493,931.9			1	342,627.5			2	2,151,304.4

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

18	Увс НДС	1	1					-	-								
19	Ховд НДС	1	1					1	7,000.0						1		7,000.0
20	Хөвсгөл НДС	1	1					-	-								
21	Хэнтий НДС	1	1					-	-								
22	Багануур НДС	1	1					2	122,778.7						2		122,778.7
23	Багахангай НДС	1	1					2	5,178.0						2		5,178.0
24	Баянгол НДС	1	1					2	525,466.6						2		525,466.6
25	Баянзүрх НДС	1	1					3	482,860.1						3		482,860.1
26	Налайх НДС	1	1					3	130,143.9			1	129,555.7		2		588.2
27	Сонгинохайрхан НДС	1	1					3	579,020.2			1	110,658.0		2		468,362.2
28	Сүхбаатар дүүргийн НДС	1	1					5	972,243.5			2	859,114.2		3		113,129.3
29	Хан-Уул НДС	1	1					2	58,415.9						2		58,415.9
30	Чингэлтэй НДС	1	1					2	76,216.6						2		76,216.6
31	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба	1					1	-	-								
32	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төв сан	1					1	1	48,655.5			1	48,655.5				
33	БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг	1					1	3	3,256,937.4						3		3,256,937.4
	Дүн	33	27	-	-	-	6	45	21,468,394.3	1	733.7	11	11,035,723.7	-	-	33	10,431,936.9
	Нийт дүн	34	27	1	-	-	6	49	169,121,375.8	1	733.7	14	158,688,705.2	-	-	34	10,431,936.9

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I. Төсвийн ерөнхийлөн захирагч											
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга	4	37,834,053.7			1	-			3	37,834,053.7
	Дүн	4	37,834,053.7	-	-	1	-	-	-	3	37,834,053.7
II. Засгийн газрын тусгай сан											
1	Говьсүмбэр аймгийн НДС	1	-			1	-				
2	Налайх дүүргийн НДС	1	-							1	-
3	НДЕГ-ын Төв сан	1	27,366,541.9			1	27,366,541.9				
4	БНСУ дахь ХНХҮТ-ийн Нийгмийн даатгалын тасаг	1	-							1	-
	Дүн	4	27,366,541.9	-	-	2	27,366,541.9	-	-	2	-
	Нийт дүн	8	65,200,595.6	-	-	3	27,366,541.9	-	-	5	37,834,053.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1369/АО111371

Улаанбаатар хот

САГ-2026/14/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Чингис хаан банканд байршиж буй Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн өмнөх оны үлдэгдэл 93,399,207,552.99 /ерэн гурван тэрбум гурван зуун ерөн есөн сая хоёр зуун долоон мянга таван зуун тавин хоёр/ төгрөгөөс тайлант онд 12.4 хувь буюу 11,553,925,106.05 /арван нэгэн тэрбум таван зуун тавин гурван сая есөн зуун хорин таван мянга нэг зуун зургаа/ төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч (үүнээс 4,061,244,056.05 /дөрвөн тэрбум жаран нэгэн сая хоёр зуун дөчин дөрвөн мянга тавин зургаа/ төгрөг нь мөнгөн хөрөнгөөр, 7,492,681,050.00 /долоон тэрбум дөрвөн зуун ерэн хоёр сая зургаан зуун наян нэгэн мянга тавь/ төгрөгийн өртөгтэй оффис, орон сууцны зориулалттай 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авсан байна) 81,845,282,446.94 /наян нэгэн тэрбум найман зуун дөчин таван сая хоёр зуун наян хоёр мянга дөрвөн зуун дөчин зургаа/ төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд дансны үлдэгдлийн баталгаа гаргаж баталгаажуулсан боловч уг хөрөнгийг банкнаас бүрэн гаргах боломжгүй бодит бус үлдэгдэлтэй хэвээр байна;

2. Шүүхийн шийдвэрийн дагуу тус банканд байршиж буй дансны үлдэгдэлд тооцсон /2020 оны 08,09,10 саруудад/ хүүгийн авлагын 1,801,879,117.00 /нэг тэрбум найман зуун нэг сая найман зуун далан есөн мянга нэг зуун арван долоо/ төгрөгийг төлбөр барагдуулах дараалал хүлээгдэж байгаагаас шалтгаалан үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх,"; 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх,"; 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах,"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga 2026\124.SAG-30.Docx

1526182178

1. Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Нийгмийн даатгалын төв санд төвлөрүүлэх ажил удаашралтай, 2020 оны шүүхийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Т.Аубакир/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1370/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/14/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өмнөх оны үлдэгдэл нийт 65,701,545,300.00 /жаран таван тэрбум долоон зуун нэг сая таван зуун дөчин таван мянга гурван зуу/ төгрөгийн авлагаас 12.4 хувь буюу 8,130,672,795.00 /найман тэрбум нэг зуун гучин сая зургаан зуун далан хоёр мянга долоон зуун ерэн тав/ төгрөгийн хөрөнгө (үүнээс 1,599,998,500.00 /нэг тэрбум таван зуун ерэн есөн сая есөн зуун ерэн найман мянга таван зуу) төгрөг нь мөнгөн хөрөнгөөр, 6,530,674,295.00 /зургаан тэрбум таван зуун гучин сая зургаан зуун далан дөрвөн мянга хоёр зуун ерэн тав/ төгрөгийн орон сууц, авто зогсоолын зориулалттай 11 үл хөдлөх хөрөнгө/ барагдуулж, нийт 57,570,872,505.00 /тавин долоон тэрбум таван зуун далан сая найман зуун далан хоёр мянга таван зуун тав/ төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Капитал банкны эрх хүлээн авагчаас авах нийгмийн даатгалын сангийн авлагын үлдэгдэл 57,570,872,505.00 /тавин долоон тэрбум таван зуун далан сая найман зуун далан хоёр мянга таван зуун тав/ төгрөгийг барагдуулах ажлыг тус банкны эрх хүлээн авагчтай хамтран эрчимжүүлж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Т.Аубакир/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1371/АД111371

Улаанбаатар хот

САГ-2026/4/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн таллан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах өмнөх оны 6,444,784,275.08 /зургаан тэрбум дөрвөн зуун дөчин дөрвөн сая долоон зуун наян дөрвөн мянга хоёр зуун далан тав/ төгрөгийн авлагын үлдэгдлээс тайлант онд дампуурсан ХОТШ банк нийт 9,836,821.73 /есөн сая найман зуун гучин зургаан мянга найман зуун хорин нэг/ төгрөгийн авлага барагдуулж, 6,434,947,453.35 /зургаан тэрбум дөрвөн зуун гучин дөрвөн сая есөн зуун дөчин долоон мянга дөрвөн зуун тавин гурав/ төгрөгийн үлдэгдэлтэй, хууль хяналтын байгууллагад хандан арга хэмжээ авч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

1. Дампуурсан болон татан буугдсан 7 банкны нийт 5,436,275,470.12 төгрөг; /Сэргээн босголт банк 2,066,646,185.67 төгрөг, ХОТШ банк 1,572,355,718.85 төгрөг, Монгол даатгал-Ардын банк 824,487,505.07 төгрөг, Экзим банк 753,219,260.53 төгрөг, Монгол бизнес банк 200,000,000.00 төгрөг, Азийн хөрөнгө оруулалтын банк 19,566,800.00 сая төгрөг/;
2. 16 аж ахуй нэгжийн нийгмийн даатгалын шимтгэлийн 909,756,672.23 төгрөг; /Тухайлбал: Нийслэлийн өмчийн газар 552,600,000.00 төгрөг, "Өндөр гэгээн" ХХК 111,765,000.00 төгрөг, Дорнын говь ХХК 150,000,000.00 төгрөг/;
3. 15 иргэний нийгмийн даатгалын шимтгэлийн 88,915,311.00 төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga 2026\0424_SAG-30.Docx

1526182182

1. Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авах нийт авлагыг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Т.Аубакир/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1372/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/14/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Нийгмийн даатгалын ерөнхий газар, Цагдаа болон Эрүүл мэндийн байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоо хангалтгүй, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг бүрэн хэрэгжүүлээгүй, энэ талаар журам, заавраар зохицуулаагүй зэргээс шалтгаалан Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шалгалтын газраас хийсэн шалгалтаар иргэд нас барсан даатгуулагчийн тохиолдлыг бүртгүүлдэггүйгээс 2023-2025 оны хооронд 721 иргэнд нийт 2,617,512,308.00 /хоёр тэрбум зургаан зуун арван долоон сая таван зуун арван хоёр мянга гурван зуун найм/ төгрөгийн тэтгэвэр олгосон зөрчил илэрсэн нь дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т "Нийгмийн даатгалын байгууллага мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, хүнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх, хяналт шалгалт хийх зорилгоор төрийн бусад байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг ашиглана.", Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.2-т "тэтгэвэр авагчийг нас барсны дараагийн сарыг дууссан өдрөөс, эсхүл тэтгэвэр авагчийг сураггүй алга болсныг тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цагдаа болон Эрүүл мэндийн байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлын уялдаа хангалтгүй, хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Т.Аубакир/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1373/А0161139

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ЗГТС

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас урьдчилан сэргийлэх ажиллагааны зардалд анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй 48,655,507.00 /дөчин найман сая зургаан зуун тавин таван мянга таван зуун долоо/ төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй дутуу ажил, гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал/, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга /Ц.Ганцэцэг/, Нийгмийн даатгалын төв сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн /М.Тамир/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1374/АО161139

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Капитал банк дахь банкны эрх хүлээн авагч болон Чингис Хаан банкнаас Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 181/ШШ2020/02624 дүгээр захирамж, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 182/ШШ2020/02419 дүгээр захирамжийн дагуу 2021-2025 онд авлагад тооцуулан хүлээн авсан нийт 27,366,541,948.32 /хорин долоон тэрбум гурван зуун жаран зургаан сая таван зуун дөчин нэгэн мянга есөн зуун дөчин найман төгрөг гучин хоёр мөнгө/ төгрөгийн үнэ бүхий 38 ширхэг үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй байгаагаас тайлант онд дээрх хөрөнгөтэй холбоотой ашиглалтын зардалд нийт 76,816,192.85 /далан зургаан сая найман зуун арван зургаан мянга нэг зуун ерэн хоёр төгрөг наян таван мөнгө/ төгрөгийг зарцуулсан;

2. Өмнөх онд 2,452,334,115.17 /хоёр тэрбум дөрвөн зуун тавин хоёр сая гурван зуун гучин дөрвөн мянга нэг зуун арван тав төгрөг арван долоон мөнгө/ төгрөгийн хөрөнгийг борлуулж байсан бол тайлант онд 189,798,159.05 /нэг зуун наян есөн сая долоон зуун ерэн найман мянга нэг зуун тавин есөн төгрөг таван мөнгө/ төгрөгийн орон сууцны зориулалттай 1 үл хөдлөх хөрөнгийг борлуулсан нь авлагад тооцож авсан хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажил удаашралтай, жил өнгөрөх тусам хөрөнгийн үнэ цэн буурах, авлагын үлдэгдэл бүрэн барагдахгүй байх, ашиглалтын зардал нэмэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 5.1.5-д "хариуцлагатай байх.", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264730

Z:\Alban Shaardlaga-2026\0424 SAG-27.Docx

1526182168

1. Капитал банк дахь банкны эрх хүлээн авагч болон Чингис Хаан банкнаас авлагд тооцуулан шилжүүлэн авсан нийт хөрөнгийг худалдан борлуулах зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга /Б.Алтанцэцэг/, Тэтгэврийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Ө.Бодьгэрэл/, Нийгмийн даатгалын төв сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн /М.Тамир/ нарт даалгав.



ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Д.БАЯРСАЙХАН
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ